**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/20/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2023.02.17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Б.Нарангэрэл
Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 6
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 12
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 14
**4.1 Ерөнхий зүйл** ........ 14
**4.2 Материаллаг байдал** ........ 15
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 15
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 16
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 16
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 17
**5.1 Төлбөрийн акт** ........ 17
**5.2 Албан шаардлага** ........ 18
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
310 дугаар байр, Лувсандanzанжанцангийн өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023. 02.24 № 2/107
танай ____________ -ны №____________ -т

БАЯНЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ С.НАНДИНЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Аудитаар илэрсэн зөрчил нь төлөвлөлтийн шатанд урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн бөгөөд бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тайлант хугацаанд цахим хэрэглээний зардлаас 840.0 мянга, хичээл практикийн зардлаас 234.9 мянга, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний зардлаас 298.9 мянга төгрөгийг зориулалт бусаар, гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллын байгууллагын менежментийг сайжруулах үйл ажиллагаанд зарцуулах 3201.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан;
- Нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас орлого 448.6 мянган төгрөгөөр дутуу, зарлага 1409.7 илүү нийт 1858.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Дотуур байрны хүүхдийн хоол 4468.2 мянга, үдийн хоол 1042.4 мянган төгрөгийн зарлагыг гаргахдаа хоолны меню бичээгүй байсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох

005020435

бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, мөн УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-12 Бараа материал болон санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Тохиолдсон байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын дүгнэлтийн үндэслэл болгосон дээрх зөрчил дутагдал нь бидний урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн, аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалтыг ажил гүйлгээний хувьд хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

# 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **118,364,822.40** | **138,895,985.66** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 19,575,795.26 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 19,575,795.26 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 19,575,795.26 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 19,575,795.26 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 1,173,118.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 1,173,118.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 62,518.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 00.00 | 1,110,600.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 118,364,822.40 | 118,147,072.40 |
| **351** | **Түүхий эд материал** | 33,992,377.00 | 29,615,827.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 23,629,077.00 | 22,874,027.00 |
| 35130 | Эм боох материал | 10,363,300.00 | 6,741,800.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 84,372,445.40 | 88,531,245.40 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 730,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 54,547,240.00 | 56,459,840.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,928,800.00 | 2,367,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 26,896,405.40 | 28,974,405.40 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,662,164,147.86** | **1,705,809,343.92** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,662,164,147.86 | 1,705,809,343.92 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,629,098,647.94 | 1,672,778,219.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,642,407,402.00 | 1,642,407,402.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -189,684,475.68 | -221,519,859.96 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 282,686,991.50 | 374,073,191.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -209,331,511.69 | -220,402,884.22 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 120,492,049.36 | 123,285,049.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -71,764,656.94 | -77,748,229.06 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 48,253,449.00 | 48,253,449.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -10,924,865.75 | -12,534,165.74 |
| 39217 | Ном | 16,964,266.14 | 16,964,266.14 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 33,065,499.92 | 33,031,124.90 |
| 39301 | Програм хангамж | 955,000.00 | 955,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -817,500.08 | -851,875.10 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,928,000.00 | 32,928,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,780,528,970.26** | **1,844,705,329.58** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,780,528,970.26** | **1,844,705,329.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,780,528,970.26 | 1,844,705,329.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 413,542,036.70 | 413,542,036.70 |
| 51101 | Өмч: - төрийн | 413,542,036.70 | 413,542,036.70 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 31,052,508.26 | 95,228,867.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 31,052,508.26 | 31,052,508.26 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 64,176,359.32 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,335,934,425.30 | 1,335,934,425.30 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,780,528,970.26** | **1,844,705,329.58** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,280,591,555.49** | **1,498,969,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **51,252,454.49** | **58,980,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 51,252,454.49 | 1,461,800.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 1,461,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,461,800.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 57,518,200.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 57,518,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **195,576,801.00** | **1,439,989,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 1,252,321,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 1,252,321,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,033,762,300.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 75,802,469.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,802,469.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 119,774,332.00 | 187,667,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 119,774,332.00 | 187,667,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,275,753,533.45** | **1,434,792,840.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,275,753,533.45** | **1,434,792,840.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,169,091,458.93 | 1,406,790,376.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 775,989,753.48 | 920,763,784.04 |
| 210101 | Үндсэн цалин | 580,670,872.20 | 614,662,809.53 |
| 210102 | Нэмэгдэл | 136,471,998.68 | 234,473,230.51 |
| 210104 | Урамшуулал | 58,846,882.60 | 35,665,964.10 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 35,961,779.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,699,386.00 | 114,851,833.92 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 73,700,886.00 | 78,406,012.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,039,500.00 | 9,111,529.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,631,600.00 | 7,289,123.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,407,900.00 | 1,822,304.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,919,500.00 | 18,222,864.89 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 115,845,532.00 | 122,820,273.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,882,833.00 | 6,680,014.00 |
| 210302 | Түлш, халаалт | 109,204,699.00 | 114,640,259.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 758,000.00 | 1,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,467,290.00 | 34,758,431.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,243,900.00 | 8,409,020.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 | 6,588,161.30 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,743,880.00 | 4,161,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 533,700.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,360,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,722,100.00 | 7,941,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 9,363,710.00 | 7,658,250.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,505,150.00 | 136,611,250.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 244,500.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,260,650.00 | 136,611,250.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,385,200.00 | 7,816,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,385,200.00 | 7,816,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 492,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 492,000.00 | 00.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,813,600.00 | 3,208,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,073,600.00 | 351,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 2,857,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 107,893,547.45 | 65,960,603.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,500,000.00 | 15,176,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,681,200.00 | 250,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 103,712,347.45 | 50,534,003.94 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 106,662,074.52 | 28,002,464.48 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 103,451,100.00 | 11,564,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,579,600.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,039,000.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,184,500.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 648,000.00 | 11,564,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 231,169.00 | 16,438,464.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 16,438,464.48 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,979,805.52 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,979,805.52 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4,838,022.04** | **64,176,359.32** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 423,156.30 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 423,156.30 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -423,156.30 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,414,865.74** | **64,176,359.32** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,229,339,101.00** | **1,441,451,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **1,461,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 1,461,800.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 1,461,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,461,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,229,339,101.00** | **1,439,989,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 1,252,321,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 1,252,321,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,033,762,300.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 75,802,469.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,802,469.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 119,774,332.00 | 187,667,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 119,774,332.00 | 187,667,300.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,229,339,101.00** | **1,385,214,204.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,229,339,101.00** | **1,385,214,204.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,122,677,026.48** | **1,289,620,740.26** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 786,066,978.48 | 920,763,784.04 |
| 210101 | Үндсэн цалин | 590,748,097.20 | 614,662,809.53 |
| 210102 | Нэмэгдэл | 136,471,998.68 | 234,473,230.51 |
| 210104 | Урамшуулал | 58,846,882.60 | 35,665,964.10 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 35,961,779.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,699,386.00 | 114,914,351.92 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 73,700,886.00 | 78,468,530.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,039,500.00 | 9,111,529.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,631,600.00 | 7,289,123.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,407,900.00 | 1,822,304.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,919,500.00 | 18,222,864.89 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 118,774,332.00 | 122,457,833.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,882,833.00 | 6,680,014.00 |
| 210302 | Түлш, халаалт | 112,133,499.00 | 114,277,819.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 758,000.00 | 1,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,677,980.00 | 00.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,243,900.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,743,880.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 833,700.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,360,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,996,500.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 55,966,350.00 | 69,020,250.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 7,978,800.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,260,650.00 | 69,020,250.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,726,900.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,185,200.00 | 8,314,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,800,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,385,200.00 | 8,314,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 492,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 492,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,753,600.00 | 10,540,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,013,600.00 | 1,461,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 9,078,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,061,200.00 | 43,610,521.30 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,480,000.00 | 29,992,576.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,581,200.00 | 13,617,945.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **106,662,074.52** | **95,593,464.48** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 103,451,100.00 | 79,155,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,579,600.00 | 67,591,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,039,000.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,184,500.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 648,000.00 | 11,564,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 16,438,464.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 16,438,464.48 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,210,974.52 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,979,805.52 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **56,236,795.26** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **36,661,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **36,661,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 36,661,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 36,661,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-36,661,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 19,575,795.26 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 19,575,795.26 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 413,542,036.70 | 1,336,761,282.30 | 25,810,785.52 | 1,776,114,104.52 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,336,761,282.30** | **25,810,785.52** | 1,776,114,104.52 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 4,414,865.74 | 4,414,865.74 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,335,934,425.30** | **31,052,508.26** | 1,780,528,970.26 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,335,934,425.30** | **31,052,508.26** | 1,780,528,970.26 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,335,934,425.30** | **31,052,508.26** | 1,780,528,970.26 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 64,176,359.32 | 64,176,359.32 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,335,934,425.30** | **95,228,867.58** | 1,844,705,329.58 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,489,561,600.00 | 1,405,436,740.26 | 84,124,859.74 | 94.4 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,489,561,600.00 | 1,405,436,740.26 | 84,124,859.74 | 94.4 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,404,299,000.00 | 1,326,281,740.26 | 78,017,259.74 | 94.4 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 940,864,100.00 | 920,763,784.04 | 20,100,315.96 | 97.9 |
| 210101 | Үндсэн цалин | 665,706,900.00 | 614,662,809.53 | 51,044,090.47 | 92.3 |
| 210102 | Нэмэгдэл | 200,645,600.00 | 234,473,230.51 | -33,827,630.51 | 116.9 |
| 210104 | Урамшуулал | 20,295,800.00 | 35,665,964.10 | -15,370,164.10 | 175.7 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 54,215,800.00 | 35,961,779.90 | 18,254,020.10 | 66.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 117,608,200.00 | 114,914,351.92 | 2,693,848.08 | 97.7 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,973,400.00 | 78,468,530.08 | 1,504,869.92 | 98.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,408,900.00 | 9,111,529.39 | 297,370.61 | 96.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,526,900.00 | 7,289,123.22 | 237,776.78 | 96.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,881,700.00 | 1,822,304.34 | 59,395.66 | 96.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,817,300.00 | 18,222,864.89 | 594,435.11 | 96.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 165,354,100.00 | 122,457,833.00 | 42,896,267.00 | 74.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,871,600.00 | 6,680,014.00 | -808,414.00 | 113.8 |
| 210302 | Түлш, халаалт | 157,982,500.00 | 114,277,819.00 | 43,704,681.00 | 72.3 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 72,718,400.00 | 69,020,250.00 | 3,698,150.00 | 94.9 |
| 210502 | Хоол, хүнс | 72,718,400.00 | 69,020,250.00 | 3,698,150.00 | 94.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,320,400.00 | 8,314,000.00 | 6,400.00 | 99.9 |
| 210604 | Урсгал засвар | 8,320,400.00 | 8,314,000.00 | 6,400.00 | 99.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,652,000.00 | 10,540,000.00 | 1,112,000.00 | 90.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,572,400.00 | 1,461,800.00 | 1,110,600.00 | 56.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,079,600.00 | 9,078,200.00 | 1,400.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 87781800.00 | 80271521.30 | 7,510,278.70 | 91.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 74,162,500.00 | 66,653,576.30 | 7,508,923.70 | 89.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,619,300.00 | 13,617,945.00 | 1,355.00 | 100.0 |

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | Зөрүү | Хувь |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 85,262,600.00 | 79,155,000.00 | 6,107,600.00 | 92.8 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 73,698,600.00 | 67,591,000.00 | 6,107,600.00 | 91.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,564,000.00 | 11,564,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,489,561,300.00 | 1,441,451,000.00 | 48,110,300.00 | 96.8 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,252,321,900.00 | 1,252,321,900.00 | 0.00 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,252,321,900.00 | 1,252,321,900.00 | 0.00 | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 234,667,000.00 | 187,667,300.00 | 46,999,700.00 | 80.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 234,667,000.00 | 187,667,300.00 | 46,999,700.00 | 80.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,572,400.00 | 1,461,800.00 | 1,110,600.00 | 56.8 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,572,400.00 | 1,461,800.00 | 1,110,600.00 | 56.8 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 19,575,795.26 | -19,575,795.26 | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 68.00 | 68.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 45.00 | 45.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 22.00 | 22.00 | 0.00 | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Хүүхдийн сурах, хөгжих үйлийг дэмжиж сурлагын чанарыг нэмэгдүүлэх, багш нарын заах арга зүй, мэдлэг чадвар, мэдээлэл, технологийн чадавхийг дээшлүүлэх, хамтын зүтгэлтэй, хариуцлагыг дээдэлсэн хамт олон болох” эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

Тус сургууль нь 480 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 2021-2022 оны хичээлийн жилд 24 бүлэгт бага анги 318, дунд ангид 223, ахлах анги 103, дүйцсэн хөтөлбөрт 27 сурагч суралцсан.

Тайлант онд үдийн цай хөтөлбөрт 318 сурагч хамрагдаж, дотуур байранд 100 хүүхэд амьдарч байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Сангийн сайдын 2018 оны тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын жишиг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,176.4 мянган төгрөгөөр *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Хувь |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 118,364.8 | 6.6% | 138,896.0 | 7.5% | 20,531.2 | 17.3% |
| Мөнгөн хөрөнгө | - | 0.0% | 19,575.8 | 1.1% | 19,575.8 | 0.0% |
| Авлага | - | 0.0% | 1,173.1 | 0.1% | 1,173.1 | 0.0% |
| Урьдчилгаа | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Бараа материал | 118,364.8 | 6.6% | 118,147.1 | 6.4% | (217.8) | -0.2% |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,662,164.1 | 93.4% | 1,705,809.3 | 92.5% | 43,645.2 | 2.6% |
| Үндсэн хөрөнгө | 2,144,687.2 | 120.5% | 2,238,866.4 | 121.4% | 94,179.2 | 4.4% |
| Хуримтлагдсан элэгдэл | (482,523.0) | -27.1% | (533,057.0) | -28.9% | (50,534.0) | 10.5% |
| **Нийт хөрөнгө** | 1,780,529.0 | 100.0% | 1,844,705.3 | 100.0% | 64,176.4 | 3.6% |
| Өр төлбөр | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,780,529.0 | 100.0% | 1,844,705.3 | 100.0% | 64,176.4 | 3.6% |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,780,529.0 | 100.0% | 1,844,705.3 | 100.0% | 64,176.4 | 3.6% |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь үндсэн дансны үлдэгдэл 19,575.8 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 118,147.1 мянган төгрөг болж 217.8 мянган төгрөгөөр буурсан нь эм боох материал данс 3,621.5 мянга, түлш шатах тослох материал данс 561.8 мянга, тусгай зориулалтын материал данс 755.0 мянган төгрөгөөр буурч бичиг хэргийн материал 730.0 мянга, бусад хангамжийн материал данс 2,097.0 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,238,866.4 мянган төгрөг болж 94,179.2 мянган төгрөгөөр өссөн нь 36,661.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, Баянхонгор аймгийн ЗДТГ-аас 10 нэр төрлийн 23,411.2 мянган төгрөгийн өртөг бүхий компьютер тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас 34,107.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,843,532.2 мянган төгрөг болж 64,176.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн-64,176.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,462,054.4 мянган төгрөгөөр, зарцуулахаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн

төслөөс 27,507.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,489,561.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,252,321.9 мянга, орон нутгийн төсвөөс 187,667.3 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 1,461.8 төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,462,054.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,405,436.7 мянган төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 20,100.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2,693.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 42,896.3 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **71802 Ерөнхий боловсрол** | **1,489,561,600.00** | **1,405,436,740.27** | **84,124,859.73** | **94.3%** |
| 2 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 3,631,800.00 | 3,631,500.00 | 300.00 | 100.0% |
| 3 | 80312 Сургалт семинар | 1,815,900.00 | 1,814,820.00 | 1,080.00 | 99.9% |
| 4 | 81605 Эрүүл мэндийг дэмжих | 4,176,600.00 | 3,588,900.00 | 587,700.00 | 85.9% |
| 5 | 81801 үдийн цай хөтөлбөр | 73,698,600.00 | 67,591,000.00 | 6,107,600.00 | 91.7% |
| 6 | 81806 Дотуур байрны үйлчилгээ | 105,535,500.00 | 101,835,078.90 | 3,700,421.10 | 96.5% |
| 7 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 41,960,000.00 | 35,061,000.00 | 6,899,000.00 | 83.6% |
| 8 | 81823 Боловсролын байгууллагын багш, | 8,171,600.00 | 8,155,641.30 | 15,958.70 | 99.8% |
| 9 | 81834 Боловсролын стандарт, сургалтын | 904,406,900.00 | 904,400,452.94 | 6,447.06 | 100.0% |
| 10 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 108,925,000.00 | 106,667,711.61 | 2,257,288.39 | 97.9% |
| 11 | 81848 Сурах бичгийн түрээс | 2,572,400.00 | 1,461,800.00 | 1,110,600.00 | 56.8% |
| 12 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 234,667,300.00 | 171,228,835.52 | 63,438,464.48 | 73.0% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй ба тус байгууллага нь тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээ сарын 10-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,275,753.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,757,5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,930.3 мянган төгрөгөөр , тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг шалгахад 2022 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,683.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байгаа нь тус байгууллагын тогны хүчин чадал боломжит түвшинд хүрдэггүйн улмаас дотуур байрны гал тогоонд нэмэлтээр 2 энгийн гар галлагаатай зуух ажиллуулснаар түлш халаалтын зардал өссөн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.3-д "Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан"-д заасан 150,390.7 мянган төгрөгийн 3 мэдээлэл, 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 1,528,745.1 мянган төгрөгийн 66 мэдээлэл, 6.4.8-д "Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл"-д заасан 700.9 мянган төгрөгийн 45 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Харин хуулийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 120,970.7 мянган төгрөгийн орлогын 5 гүйлгээг, 15,936.1 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроож, 19,899.6 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг огт мэдээлээгүй, 6.4.8-д "Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл"-д заасан 63,902.1 мянган төгрөгийн 2 мэдээллийг мэдээлээгүй, мөн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол нийлүүлэх гэрээ, цахим худалдан авалтын гэрээ зэргийг байршуулаагүй байна.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж аудитаар 168,726.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2022.05.30-ний өдрийн 31 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 0 | 0 | 0 | 0 | |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | |
| Зөвлөмж | 3 | 168,726.6 | 3 | 168,726.6 | 100 |
| **Нийт дүн** | **3** | **168,726.6** | **3** | **168,726.6** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т " Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг БСУШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба тус сургуулийн дотуур байрны хоол хүнсний зардлаас 3,698.2 мянга, үдийн хоолны зардал 6,107.6 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,173.1 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны нийгмийн даатгалд илүү төлсөн 62,5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.
2. Тайлант хугацаанд түрээсийн сурах бичгийн үнэ 1110.6 мянган төгрөг төвлөрөөгүй бөгөөд санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Аудитаар нийт 14,719.7 мянган төгрөгийн зөрчил[2] 11 илэрснээс, 2,456.7 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 11,702.7 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 560.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тус сургуулийн захирал өөртөө шийдвэр гаргаж байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал болох 868.2 мянган төгрөгийг хүлээн авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсвийн захирагчаар 868.2 мянган төгрөгийг төлүүлж, төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Мэдээлэл технологийн зардлаас сургуулийн захирал, нягтлан, сургалтын менежер, нийгмийн ажилтан, нярав, бичиг хэргийн ажилтанд нийт 5-р сард 200.0 мянга, 8-9 сард 175.0 мянга, 12-р сард 180.0 мянга, 6-р сард захирал, сургалтын менежер, нягтлан, няравт нарт 100.0 мянга, 10-11 сард захирал, нягтлан бодогчид 185.0 мянган төгрөгийн интернэтийн төлбөрийг төлсөн байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зориулалт бусаар зарцуулсан 840.0 мянган төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж, орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3 Хичээл практикийн зардлаас 7, 8 дугаар саруудад 234.9 мянган төгрөгийг шатахууны зардалд  зарцуулсан, мөн Амарбуянт хийдэд хүндэтгэлийн гэр барих ажилд 52.2 мянган төгрөгийн шатахууныг тус тус зарцуулсан

Энэ  нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зориулалт бусаар зарцуулсан 234.9 мянган төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж, орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.4 Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний зардлаас 298.9 мянган төгрөг шатахууны зардалд зарцуулсан байна.

Энэ нь  Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-д заасан нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй зааврын 4-г зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зориулалт бусаар зарцуулсан 298.9 мянган төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж, орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.5 Тайлант хугацаанд "Утга нуур" ХХК-тай сурагчдын үдийн хоол нийлүүлэх гэрээг 2022.05.20-ний өдөр хийсэн бөгөөд гэрээний үнийг тулгахад  162.5 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээний үнээс илүү үнээр худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлж, ОНО-т төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас орлого 448.6 мянган төгрөгөөр дутуу , зарлага 1409.7 илүү нийт 1858.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Нягтлан бодогч болон эд хариуцагч нар дутуу болон зөрүүтэй тусгасан гүйлгээг бүртгэж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

5.2.2 Тус байгууллагын даргын 2022.01.06-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар орон тоонд хүний нөөцийн орон тоог батлаагүй байхад архив, бичиг хэргийн ажилтанд 2022.03.05-ны өдрөөс эхлэн хүний нөөцийн нэгдсэн системийг хариуцуулан ТҮ-5-1 шатлалын 562911 төгрөгийн цалингийн 20%-ийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Байгууллагын даргын бүтэц орон тоо батлах тухай тушаалын дагуу орон тоог мөрдөж, төсөвт тусгагдаагүй нэмэлт зардал гаргадаг байдлыг таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.3 Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан орлогын 120,970.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 15,936.2 мянган төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож, 19,899.6 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй, хуулийн 6.4.8-д заасан 63,902.1 мянган төгрөгийн 2 шийдвэрийг мэдээлээгүй, мөн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол нийлүүлэх гэрээ, цахим худалдан авалтын гэрээ зэргийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 " Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ", 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасан 220,708.6 мянган төгрөгийн 8 гүйлгээг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.2.4 Тус сургуулийн хүнсний тайланг тулгахад дотуур байрны хүүхдийн хоол 4468.2 мянга, үдийн хоол 1042.4 мянган төгрөгийн меню бичээгүй зарлага гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Байгууллагын өмч хамгаалах зөвлөл, дотоод хяналтаар дээрх аудитаар илэрсэн алдааг хянаж, тооцоог дахин нягтлан хариу албан шаардлага өгөв.

5.2.5 Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллын байгууллагын менежментийг сайжруулах үйл ажиллагаанд зарцуулах 3201.0 мянган төгрөгийг УБ хотод туршлага судлахаар нярав З.Сумьяабазарын данс руу 2023.12.26-ны өдөр шилжүүлсэн бөгөөд уг зардалтай холбоотой тайланг гаргаагүй, үр дүнг тооцоогүй, юунд зарцуулсан эсэх нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас зарцуулсан 3,201.0 мянган төгрөгийн хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт: Т*ус сургуулийн захирлын 2022.11.21-ний өдрийн А/65 дугаар тушаалаар 4-р улирлын ажлын үзүүлэлтийг урьдчилан үнэлж нэр бүхий 6 ажилтанд ур чадварын нэмэгдэл 20% олгосон байна.

Энэ нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дүгээр тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2-дахь заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*: Ажилчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын дагуу үнэлж, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайланд бүртгээгүй | 2 | 1,173.1 | 2 | 1,173.1 | | | 2 | 1,173.1 | | |
| Дүн | **2** | **1,173.1** | **2** | **1,173.1** | | | **2** | **1,173.1** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус сургуулийн захирал өөртөө шийдвэр гаргаж байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал болох 868200 төгрөгийг хүлээн авсан байна. | 1 | 868.2 | 1 | 868.2 | | | | |
| Мэдээлэл технологийн зардлаас сургуулийн захирал, нягтлан, сургалтын менежер, нийгмийн ажилтан, нярав, бичиг хэргийн ажилтанд нийт 5-р сард 200.0 мянга, 8-9 сард 175.0 мянга, 12-р сард 180.0 мянга, 6-р сард захирал, сургалтын менежер, нягтлан, няравт нарт 100.0 мянга, 10-11 сард захирал, нягтлан бодогчид 185.0 мянган төгрөгийн интернэтийн төлбөрийг төлсөн байна. | 1 | 840.0 | 1 | 840.0 | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хичээл практикийн зардлаас 7, 8 дугаар саруудад 234.9 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан, мөн Амарбуянт хийдэд хүндэтгэлийн гэр барих ажилд 52.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. | 1 | 287.1 | 1 | 287.1 | | | | |
| Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний зардлаас 298.9 мянган төгрөг шатахууны зардалд зарцуулсан байгаа нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-д заасан нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй зааврын 4-г зөрчсөн байна. | 1 | 298.9 | 1 | 298.9 | | | | |
| Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллын байгууллагын менежментийг сайжруулах үйл ажиллагаанд зарцуулах 3201.0 мянган төгрөгийг УБ хотод туршлага судлахаар нярав З.Сумьяабазарын данс руу 2023.12.26-ны өдөр шилжүүлсэн бөгөөд уг зардалтай холбоотой тайланг гаргаагүй, үр дүнг тооцоогүй, юунд зарцуулсан эсэх нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. | 1 | 3,201.0 | | | 1 | 3,201.0 | | |
| Тайлант хугацаанд "Утга нуур" ХХК-тай сурагчдын үдийн хоол нийлүүлэх гэрээг 2022.05.20-ний өдөр хийсэн бөгөөд гэрээний үнийг тулгахад 162.5 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээний үнээс илүү үнээр худалдан авсан байна. | 1 | 162.5 | 1 | 162.5 | | | | |
| Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас орлого 448.6 мянган төгрөгөөр дутуу , зарлага 1409.7 илүү нийт 1858.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна. | 1 | 1,858.3 | | | 1 | 1,858.3 | | |
| Тус байгууллагын даргын 2022.01.06-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар орон тоонд хүний нөөцийн орон тоог батлаагүй байхад архив, бичиг хэргийн ажилтан Т.Анударьд 2022.03.05-ны өдрөөс эхлэн хүний нөөцийн нэгдсэн системийг хариуцуулан ТҮ-5-1 шатлалын 562911 төгрөгийн цалингийн 20%-ийг олгосон байна. | 1 | 1,132.8 | | | 1 | 1,132.8 | | |
| Тус сургуулийн захирлын 2022.11.21-ний өдрийн А/65 дугаар тушаалаар 4-р улирлын ажлын үзүүлэлтийг **урьдчилан** үнэлж нэр бүхий 6 ажилтанд ур чадварын нэмэгдэл 20% олгосон байна. | 1 | 560.3 | | | | | 1 | 560.3 |
| Тус сургуулийн хүнсний тайланг тулгахад дотуур байрны хүүхдийн хоол 4468.2 мянга, үдийн хоол 1042.4 мянган төгрөгийн менюгүй зарлага гаргасан байна. | 1 | 5,510.6 | | | 1 | 5,510.6 | | |
| **Нийт дүн** | **10** | **14,719.7** | **5** | **2,456.7** | **4** | **11,702.7** | **1** | **560.3** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой. | | | | | | | | |
| Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан орлогын 120,970.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 15,936.2 мянган төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож, 19,899.6 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй, хуулийн 6.4.8-д заасан 63,902.1 мянган төгрөгийн 2 шийдвэрийг мэдээлээгүй, мөн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол | 1 | 0 | | | 1 | 0 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| нийлүүлэх гэрээ, цахим худалдан авалтын гэрээ зэргийг байршуулаагүй байна. | | | | | | | | |
| Дүн | **1** | **0** | | | **1** | **0** | | |

------------оОо-------------